



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/39

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 24 дэх зүйлийн 24.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/304 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хөгжлийн үндсэн чиглэл, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-мониторинг хийх, үр дүнг олон нийтэд тайлагнах үүрэг бүхий байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.

2.Сумын салбар дундын, олон талт ажлын хэсгийн ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон түүнд уялдсан үйл ажиллагааны зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойн албан татвар болон бусад боломжит эх үүсвэрээс орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх саналыг боловсруулан Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.

4.Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, орон нутгийн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог хангах замаар санал авч тусгуулах, төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.

5.Батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай арга хэмжээний зардлыг дараа оны орон нутгийн төсөвт тусгах саналыг боловсруулан Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.

6.Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт мониторинг хийж үр дүнг улирал бүр багийн Иргэдийн Нийтийн Хурал болон олон нийтэд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

сумын Засаг даргын 2026 оны
01. дүгээр сарын 12-ны өдрийн
А/39 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунгэрэл	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Ё.Мөнх-Өлзий	Газрын даамал
Гишүүд: Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын дарга
Б.Давхарбаяр	Хэнтий Шинэс Сум дундын ойн ангийн дарга
Х.Саруултуяа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Т.Одончимэг	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Т.Эрдэнэтуяа	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Чинхуяг	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Д.Өлзийсайхан	Хан хэнтий тусгай хамгаалалтын захиргааны газрын улсын байцаагч
О.Отгонбаяр	Стрийм+ төслийн орон нутгийн зохицуулагч
Багийн Засаг дарга нар	
Д.Батболд	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн төлөөлөл
А.Жаргалсайхан	Газар ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл
Т.Уянга	Эмэгтэйчүүдийн бүлэг, холбоо
М.Мөнхжаргал	Захирагчийн ажлын албаны дарга
Б. Баярсайхан	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
Э. Батхүрэл	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Б.Жаргалсайхан	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

сумын Засаг даргын 2026 оны
..... дүгээр сарын-ны өдрийн
....дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ-МОНИТОРИНГ ХИЙХ СУМЫН САЛБАР ДУНДЫН,
ОЛОН ТАЛТ АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ**

НЭГ. ЗОРИЛГО

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт-мониторинг хийх сумын салбар дундын, олон талт Ажлын хэсэг нь дараах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1. Газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг харгалзан боловсруулж буй аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

1.2. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад жендерийн мэдрэмжтэй, нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах замаар газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг харгалзсан эсэхийг хэлэлцэж санал, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, саналаа тусгуулах, батлуулах, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, батлагдсан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, холбогдох арга хэмжээний зардлыг дараа оны орон нутгийн төсөвт суулгуулах;

1.3. Жил бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний салшгүй бүрдэл байдлаар боловсруулах, хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, үр дүнг олон нийтэд тайлагнах;

ХОЁР. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГЛЭЛ

2.1 Дараах зохион байгуулалтаар ажиллана.

2.1.1. Ажлын хэсэг улиралд 1 удаа батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу хуралдаж, үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэх, санал солилцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу холбогдох албан тушаалтанд хүргүүлэх байдлаар ажиллана.

2.1.2 Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэн хурлын тэмдэглэл хөтөлж, ажлын хэсгийн даргаар баталгаажуулан сумын Засаг даргад танилцуулна.

2.1.3. Ажлын хэсгээс гарсан санал, зөвлөмжийг сумын Засаг даргад танилцуулсаны дагуу хамтын шийдэл бүхий санал, зөвлөмж гаргах зааврын дагуу ажлын хэсгийн ахлагч холбогдох албан тушаалтанд чиглэл өгнө.

ГУРАВ. ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

3.1. Ажлын хэсэг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, ажлын хэсгийн хийсэн ажлын тайланг улирал бүр сумын иргэд, олон нийтэд хурал, уулзалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн арга хэлбэрээр танилцуулж ажиллана.